

4.7 Ажлын харилцаа цуцлах зааварчилгаа

4.7 Ажлын харилцаа цуцлах


Энэ үйлдлийг хөдөлмөрийн гэрээг цуцлах үед хэрэглэнэ.

Ажилтны хөдөлмөрийн гэрээг цуцлахын тулд **ажлын харилцаа цуцлах** үйлдлийг хийхэд дараах дарааллыг баримтална. Үүнд:


1. Хүний нөөцийн удирдлагын **ажилтны жагсаалт модулийг** сонгоно.
2. Ажилтны жагсаалтаас **ажлын харилцаа цуцлах** ажилтны нэрийн мөрийг идэвхжүүлж, үйлдэл цэсээс хувийн мэдээлэл товчийг дарах эсвэл ажилтны нэр дээр дарна.
3. Хувийн мэдээлэл цонхны **Ажил эрхлэлт** хэсэг дээр дарахад баруун хэсэгт ажил эрхлэлт цонх нээгдэнэ.
4. Цонхны **үйлдэл** цэсийг дарж албан **Ажлын харилцаа цуцлах** товчийг дарна.
5. **Ажлын харилцаа цуцлах** талбарыг бөглөж хадгална.

Ажлын харилцаа цуцлах алхамчилсан дараалал дараах байдалтай байна.

- Хүний нөөцийн удирдлагын **ажилтны жагсаалт** модулийг сонгоход дараах цонх нээгдэнэ.
- Ажлын харилцаа цуцлах ажилтны нэр дээр дарах эсвэл ажилтны нэрийг идэвхжүүлээд үйлдэл цэсээс хувийн мэдээлэл үйлдлийг дарахад ажилтны хувийн мэдээллийн дараах цонх нээгдэнэ.



- Ажилтны хувийн мэдээллийн **ажил эрхлэлт** хэсгийн **үйлдэл** товч дээр байрлах **Ажлын харилцаа цуцлах** үйлдлийг сонгоно.



- Ажлын харилцаа цуцлах хэсгийг асуулгын дагуу бүрэн гүйцэд бөглөн **хадгалаад хаах** товч дарна.

- Ажлын харилцаа цуцлах шалтгаан хэсгээс сонголтыг хийнэ.
- Хэрэглэгчийн эрхийг цуцлах эсэхийг **яг одоо цуцлах, харилцаа цуцлагдсаны дараа** гэсэн сонголтоос сонгоно.
- Дахин ажилд авахад сануулах эсэхийг **тийм, үгүй** гэсэн сонголтоос сонгож **хадгалах** товч дарна.

Хүний нөөцийн удирдлага

Б.Мөнхцэцэг: Хувийн мэдээлэл

АЖЛЫН ХАРИЛЦАА ЦУЦЛАХ

Хаах Хадгалаад хаах

★ Нярав

Цуцлах ажил эрхлэлт Нярав

* Ажлын харилцаа цуцлах өдөр 2022-03-29

* Ажлын харилцаа цуцлах шалтгаан

Хэрэглэгчийн эрх цуцлах

○ Яг одоо цуцлах
 Харилцаа цуцлагдсаны дараа

Дахин ажилд авахад сануулах

○ Тийм
 Үгүй